

1. Ажлын байрны дадлагажуулагч бэлтгэх анхдугаар сургалт зохион байгуулагдлаа

Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн хөдөлмөр эрхлэлтэд дэмжлэг үзүүлэх ажлын байрны дадлагажуулагч бэлтгэх анхдугаар семинар 2023 оны 3-р сарын 27-30-ны өдрүүдэд амжилттай зохион байгуулагдлаа.

ХНХЯ-ны Хүн амын бодлогын хэрэгжилтийг зохицуулах газрын дарга С. Тунгалагтамир сургалтыг нээж үг хэлэв. Түүний дараа төслийн ахлах зөвлөх Чиба Хисао нь Монгол сургагч багш нар бэлтгэгдэн энэ удаагийн сургалтыг удирдаж байгааг онцлов.

Сургалтын эхний өдөр “Ажлын байрны дадлагажуулагчийн чиг үүрэг”, “Ажлын байрны дадлагажуулагчийн дэмжлэгийн ерөнхий үйл явц”, “Хөгжлийн бэрхшээлийн талаарх ойлголт, хөдөлмөр эрхлэх ач холбогдол”, “Хөгжлийн бэрхшээлийн онцлог, хөдөлмөр эрхлэлтийн дэмжлэг” гэсэн сэдвээр илтгэл танилцууллаа. ХНХЯ-ны ХББИХХ-ийн мэргэжилтэн Б.Болороо Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн хөдөлмөр эрхлэлтийн хууль, тогтоомжийн талаар танилцуулга хийлээ.



Ажлын байрны дадлагажуулагч бэлтгэх 8 сургагч багш



Дасгал ажлын үеэр

Харин сургалтын хоёр дахь өдөр “Хөгжлийн бэрхшээлтэй хүнд үнэлгээ хийх”, “ААНБ-ын мэдээлэл цуглуулах-Ажлын байр олох” гэсэн хоёр сэдвээр лекц тавив. Дээрх сэдвүүд нь ажлын байрны дадлагажуулагчийн заавал мэдэх ёстой ур чадвар бөгөөд сургалтад оролцогчдоор дасгал ажил ажиллуулах зэргээр онол практик хосолсон, оролцогчдын оролцоог хангасан сургалт боллоо.

Сургалтын урьдчилсан бэлтгэлийн хүрээнд Японы Ооцүма охидын их сургуулийн профессор Огава Хироши багш 3-р сарын 13-наас 17-ны өдрүүдэд Монголд ирж ажилласан ба тус хугацаанд сургагч багш нарт заавар зөвлөгөө өгөв. Харин зөвлөх багш Инаба К-Кэнтаро, Сакаи Дайсүкэ нар Япон улсаас хүрэлцэн ирж сургалтын үндсэн үйл явцад дэмжлэг үзүүлэн зөвлөгөө өгч ажиллалаа. Япон зөвлөх багш нарын хувьд ажлын байрны дадлагажуулагчаар анх ажлын гараагаа эхэлж байсан бол одоо Япон улсдаа төдийгүй Малайз, Иордан, Монгол зэрэг улс орнуудад ажлын байрны дадлагажуулагч бэлтгэх мэргэшсэн зөвлөхөөр ажиллаж байгаа юм.



Зөвлөх багш Сакаи Дайсүкэ болон Инаба Кэнтаро



Анхдугаар сургалтын төгсөгчид

Найман сургагч багш тус тусын сэдвээр лекц орж ажлын байрны дадлагажуулагчийн зайлшгүй эзэмших шаардлагатай ур чадваруудыг багтаасан агуулгыг онол, практик хосолсон хэлбэрээр заасан нь оролцогчдод ихэд таалагдсан юм. Сургалт 4 өдөр үргэлжилж ААНБ, төр, ТББ, хөдөлмөрийн биржийн нийт 35 хүн ажлын байрны дадлагажуулагчийн гэрчилгээгээ гардан авав.

DPUB2 төслийн зүгээс Ажлын байрны дадлагажуулагч гэсэн ажил мэргэжлийн хамгийн анхны түүчээлэгч болж дараа дараачийн олон олон

хүмүүст сайн жишээ болж ажиллахыг хүсэн ерөөе.

2. ААНБ-уудад хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн хөдөлмөр эрхлэлтийн талаар ойлголт өгөх 8 дахь удаагийн семинар зохион байгуулагдлаа



Семинарын оролцогчид

DPUB2 төсөл 2023 оны 4 дүгээр сарын 19-нд ААНБ-уудад нөлөөлөх 8 дахь удаагийн семинарыг зохион байгуулж, тус семинарт 25 байгууллагын нийт 28 хүн оролцлоо. Төслийн зүгээс бэлтгэгдсэн багш нар семинарыг удирдан, Жайкагийн мэргэжилтэн Японы Мираиро компанийн ажилтнуудтай хамтран сургалт явуулав. Тус сургалтад 4 ажлын байрны дадлагажуулагч болон ААНБ-уудад нөлөөлөх хүний нөөцөөр бэлтгэгдэхээр сонгогдсон 18 хүн ажиглагчаар оролцлоо.

Сургалтаар хөгжлийн бэрхшээлтэй иргэдийг ажиллуулж байгаа ААНБ-уудын сайн туршлага, хөдөлмөр эрхлэлтийг

дэмжих хууль эрхзүйн тогтолцоо, ажлын байрны тохируулга, тэгш хүртээмжтэй ажлын байрны орчныг бүрдүүлэх арга, хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн хөдөлмөр эрхлэлтийн дэлхий нийтийн чиг хандлага зэргийн талаар суралцлаа.

Тус сургалтыг “HR Club” буюу Манлайлагч хүний нөөцийн менежерүүдийн клубтэй хамтран зохион байгуулсан бөгөөд төслийн зүгээс цаашид ч тус клубтэй хамтран ажиллаж, хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн хөдөлмөр эрхлэлтийг нэмэгдүүлэх тал дээр хичээнгүйлэн ажиллахаар төлөвлөж байна.



Дурсгалын зураг

3. DPUB2 төсөл ААНБ-уудад нөлөөлөх хоёрдугаар үеийн хүний нөөцийг бэлтгэх сургалтыг зохион байгууллаа



Сургалтын оролцогчид

DPUB2 төсөл 2023 оны 4-р сарын 20, 21-ний өдрүүдэд ААНБ-д нөлөөлөх хүний нөөц бэлтгэх 2 дахь удаагийн сургалтыг амжилттай зохион байгууллаа. Тус сургалтыг Жайкагийн мэргэжилтэн, Япон улсын Мираиро компанийн ажилтан Ишии, Харагүчи, Кондо нар удирдан явууллаа.

ААНБ-уудын хувьд хөгжлийн бэрхшээлтэй иргэдийг ажилд авах хүсэл сонирхол байдаг. Гэвч хөгжлийн бэрхшээлийн талаарх ойлголт, хүртээмжтэй ажлын байр, ажлын байрны тохируулга, төрийн бодлого, хууль эрхзүйн талаарх мэдлэг мэдээлэл хомс байдаг тул хөдөлмөрийн харилцаа амжилттай үргэлжилдэггүй байх тохиолдол цөөнгүй.

ААНБ-уудад эдгээр ойлголт, мэдээллийг өгсөнөөр хөдөлмөрийн харилцаа үр дүнтэй, тогтвортой, амжилттай үргэлжилдэг. Иймээс энэхүү ойлголтыг өгдөг хүний нөөцийг өнгөрсөн жилээс бэлтгэж эхэлсэн бөгөөд энэ жил хөгжлийн бэрхшээлтэй иргэдийг багтаасан нийт 18 хүн тус сургалтад хамрагдлаа.

Сургалт хоёр өдөр үргэлжилж DPUB2 төслийн ахлах зөвлөх Чига Хисао, ХНХЯ-ны Хүн амын хөгжлийн бодлогын хэрэгжилтийг зохицуулах газрын дарга С.Тунгалагтамир нар төгсөгчидөд амжилт хүсч гэрчилгээ гардуулав.



Хоёр дахь үеийн төгсөгчид



dpub.jica@gmail.com



Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яам, Монгол Улс, Улаанбаатар-15160, Чингэлтэй дүүрэг 4-р хороо, Нэгдсэн Үндэстний гудамж-5



<https://www.facebook.com/jicadpub1and2>



<https://www.jica.go.jp/project/mongolian/mongolia/030/index.html>

